



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/227

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас эмчлүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэн Б.Энхмаа, Б.Нандавсүрэн нарт тус бүр 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд зарцуулагдах нийт 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ